

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202...он... сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ДАВАН ТУУЛАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах, дасан зохицох, нөлөөлөл, эрсдэл, эмзэг байдал, гарз хохирол, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, экосистемийн тэнцвэр, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль тогтоомж

2.1.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чадавхыг сайжруулах, дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ногоон санхүүжилтийн хөшүүргийг ашиглах, хүлэмжийн хийн тооллого, хяналт, баталгаажуулалт, тайлагналт болон карбон зах зээлийн тогтолцоог бүрдүүлэх хүрээнд энэ хууль үйлчилнэ.

3.2.Уур амьсгалын өөрчлөлт, нөлөөлөлтэй холбоотой энэ хуулиар зохицуулаагүй харилцааг холбогдох бусад хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“даван туулах” гэж аюултай үзэгдэл, тогтворгүй өөрчлөлт тулгарахад нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтолцоо үндсэн чиг үүргээ тэсвэрлэн хадгалж үлдэх замаар хариу үйлдэл үзүүлэх, дахин зохион байгуулагдахыг;

4.1.2.“дасан зохицох” гэж байгаль орчин, нийгэм, эдийн засагт бодитой учирсан эсхүл ирээдүйд тохиолдох магадлалтай уур амьсгалын өөрчлөлт, экосистемийн өртөх эмзэг байдлыг бууруулах, даван туулахад чиглэсэн чадавхыг бэхжүүлэх тогтвортой үйл ажиллагааг;

4.1.3.“карбон зах зээл” гэж дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад оролцох хүрээнд хүлэмжийн хийн ялгарлын бууруулалт, шингээлтийн үр дүнг худалдах, арилжих, дүйцүүлэх, шилжүүлэх үйл ажиллагаа, зах зээлийн механизмыг;

4.1.4.“карбоны сайн дурын зах зээл” гэж хүлэмжийн хийн ялгарлын бууруулалт, зайлуулалт, дүйцүүлэлтээс үүссэн карбон кредитийг сайн дурын үндсэн дээр арилжаалах, шилжүүлэх үйл ажиллагаа явуулах зориулалттай төвлөрсөн бус зах зээлийг;

4.1.5.“карбон кредит” гэж нэг тонн нүүрстөрөгчийн давхар ислийн ялгарлыг бууруулсантай тэнцэх худалдах, арилжих, шилжүүлэх, дүйцүүлэх нэгжээр илэрхийлэгдэх баталгаажсан эрхийг;

4.1.6.“малтмал түлш” гэж органик гаралтай биетийн үлдэгдлээс үүсэлтэй, хий, шингэн, хатуу төлөвт оршдог тодорхой хэмжээний нүүрс-устөрөгч агуулсан ашигт малтмалыг;

4.1.7.“ногоон санхүүжилт” гэж уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах, хүлэмжийн хийг бууруулах, биологийн олон янз байдлыг дэмжих болон гарз хохирол, эмзэг байдалд зориулсан санхүүжилт, хөрөнгө оруулалтыг;

4.1.8.“ногоон таксономи” гэж агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг тэсвэрлэх, даван туулах, хүлэмжийн хийг бууруулах, биологийн олон янз байдлыг дэмжих болон гарз хохирол, эмзэг байдлыг бууруулах зорилготой шалгуур үзүүлэлт бүхий байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааны ангиллыг;

4.1.9.“уур амьсгалын өөрчлөлт” гэж байгалийн болон хүний үйл ажиллагааны улмаас уур амьсгалын төлөв байдалд гарч буй урт хугацаанд үргэлжлэх өөрчлөлтийг;

4.1.10.“Үндэсний зорилт” гэж уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд хариу арга хэмжээ болгож Монгол Улсын олон улсын гэрээний зорилтыг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийг;

4.1.11.“хүлэмжийн хий” гэж байгалийн болон хүний үйл ажиллагааны улмаас агаар мандалд ялгарч, дэлхийн гадаргаас цацарч буй дулааныг тогтоож агаарын температурыг ихэсгэн хүлэмжийн нөлөөлөл үзүүлдэг нүүрсхүчлийн хий, метан, азотын дутуу исэл болон бусад хийг;

4.1.12.“хүлэмжийн хийн тооллого” гэж холбогдох журам, аргачлалын дагуу улсын, бүс нутгийн, эдийн засгийн салбарын хэмжээнд хүлэмжийн хийн ялгарлыг тооцох, тоолох цогц арга хэмжээг;

4.1.13.“хүлэмжийн хийн тэнцвэр” гэж хүлэмжийн хийн ялгарал, түүнийг бууруулах, шингээх арга хэмжээний үр дүнгийн тэнцвэрийг хангахыг;

4.1.14.“хүлэмжийн хийн шингээлт” гэж ой, ургамлын бүрхэвч, хөрс, ус болон бусад экосистем хүлэмжийн хийг хэрэглэх биологийн үйл явцыг;

4.1.15.“хүлэмжийн хийн ялгарал” гэж хүлэмжийн хий агаар мандалд ялгарч гарахыг;

4.1.16.“хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах” гэж хүлэмжийн хийн ялгарлаас урьдчилан сэргийлэх, ялгарлын үүсвэр болон хэмжээг багасгах, агаар мандлаас зайлуулах, агуулах, шингээх замаар агаар мандал дахь хүлэмжийн хийн нийт хэмжээг бууруулах үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг;

4.1.17.“хүлэмжийн хийн ялгарлын бууралт” гэж хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээ, үйл ажиллагааны үр дүнг;

4.1.18.“дүйцүүлэх” гэж хувь хүн, хувийн хэвшил, төрийн болон төрийн бус байгууллага хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээх зорилгоор бусад этгээдийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, зохион байгуулах замаар хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг тооцуулахыг.

5 дугаар зүйл.Үйл ажиллагаанд баримтлах зарчим

5.1.Энэ хуулиар зохицуулах харилцаанд дараах зарчмыг баримтална:

- 5.1.1.ил тод, нээлттэй байх;
- 5.1.2.талуудын оролцоог хангах;
- 5.1.3.шинжлэх ухаанд үндэслэх;
- 5.1.4.менежментийн нэгдсэн бодлоготой байх;
- 5.1.5.чадавхыг бэхжүүлэх;
- 5.1.6.олон улсын хэм хэмжээг баримтлах;
- 5.1.7.байгаль орчны цогц байдлыг хангах.

5.2. Энэ хуулийн 5.1-д заасан зарчмыг доор дурдсан агуулгаар ойлгоно:

5.2.1.“ил тод, нээлттэй байх” гэж хуулиар хамгаалагдсан төрийн болон албаны нууцын зэрэглэлтэй мэдээлэл агуулснаас бусад тохиолдолд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг даван туулах, дасан зохицох, хүлэмжийн хийн тэнцвэрийг хангах үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаарх мэдээлэл олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байхыг;

5.2.2.“талуудын оролцоог хангах” гэж холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, иргэд, сонирхлын бүлгийн оролцоог хангахыг;

5.2.3.“шинжлэх ухаанд үндэслэх” гэж нийгэм, эдийн засаг, байгаль газарзүйн нөхцөл, уламжлалт мэдлэг, инновац, дэвшилтэт технологи, судалгаанд үндэслэхийг;

5.2.4.“менежментийн нэгдсэн бодлоготой байх” гэж агаар, ой, усны нөөц, хөрс, газар ашиглалт, биологийн олон янз байдал зэрэг байгалийн нөөцийг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд болон бусад үйл ажиллагаанд нэгдсэн бодлого баримтлахыг;

5.2.5.“чадавхыг бэхжүүлэх” гэж уур амьсгалын өөрчлөлтийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, дасан зохицох, даван туулах, бэлэн байдлыг хангах чадавхыг төлөвшүүлэхийг;

5.2.6.“олон улсын хэм хэмжээг баримтлах” гэж Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц болон бусад олон улсын гэрээ, хэлэлцээр, тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, удирдамж, зөвлөмж, хэм хэмжээг харгалзахыг;

5.2.7.“байгаль орчны цогц байдлыг хангах” гэж экосистемийн бүрэлдэхүүн хэсэг, үйл явцын экологийн тэнцвэртэй, тогтвортой, эрүүл төлөв байдлыг хадгалахыг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААРХИ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ, ЧИГ ҮҮРЭГ

6 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

6.1.Улсын Их Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.төрөөс уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг даван туулах, дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх талаар баримтлах бодлогын баримт бичгийг батлах;

6.1.2.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, тухайн жилийн төсвийн төсөлд энэ хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг тусган батлах, хяналт тавих;

6.1.3.хуульд заасан бусад бүрэн эрх.

7 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

7.1.Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.Үндэсний зорилт болон Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөө, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой баримт бичгийг батлах, хэрэгжилтийг хангах, хяналт тавих;

7.1.2.энэ хуулийн биелэлт, холбогдох бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүнг Улсын Их Хуралд тайлагнах;

7.1.3. ногоон санхүүжилтийн хөшүүрэг, хэрэгслийг энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх;

7.1.4.ногоон санхүүжилт татах зорилгоор хоёр талт болон олон талт гэрээ, хэлэлцээрийг энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу байгуулах;

7.1.5.олон улсын ногоон санхүүжилт олгодог байгууллагад Засгийн газрыг төлөөлөх байгууллагыг томилох;

7.1.6.чадавхыг бэхжүүлэх, олон талын оролцоог нэмэгдүүлэх;

7.1.7.уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хороог байгуулж, дүрмийг батлах;

7.1.8.хуульд заасан бусад.

8 дугаар зүйл.Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хорооны чиг үүрэг

8.1.Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хороо /цаашид “Хороо” гэх/ дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.1.1.энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар салбар дундын удирдлага, зохицуулалтыг хангах;

8.1.2.уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах, дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх карбон зах зээлийн асуудлаар:

8.1.2.1.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах асуудлаар салбар дундын нэгдсэн санал, зөвлөмж гаргах;

8.1.2.2.шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох шийдвэрт тусгуулах санал гаргах;

8.1.2.3.энэ хуулиар зохицуулсан асуудлаар санал, зөвлөмж, шийдвэр гаргаж холбогдох төрийн болон орон нутгийн байгууллагад хүргүүлэх;

8.1.2.4.Үндэсний зорилт, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөө, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгах санал гаргаж, хүргүүлэх;

8.1.2.5.шаардлагатай судалгааны тайлан, мэдээллийг холбогдох төрийн болон эрдэм шинжилгээний байгууллагаас гаргуулан авах;

8.1.2.6.уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх, дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх эдийн засгийн салбар, бүс нутгийг тодорхойлох.

8.1.3. Монгол Улс уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой Олон улсын гэрээний дагуу тайлагнахаар үүрэг хүлээсэн тайланг хэлэлцэн баталгаажуулах.

8.2.Хорооны дарга нь Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, нарийн бичгийн дарга нь Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

8.3.Хорооны бүрэлдэхүүнийг Засгийн газар томилно.

8.4.Хороо нь орон тооны ажлын албатай байна. Ажлын албаны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

8.5.Хороо нь орон тооны бус мэргэжлийн зөвлөл, дэд хороо, орон нутагт салбар хороотой байж болно.

8.6.Дэд хороо, салбар хороо нь үйл ажиллагааны тайлангаа Хороонд хүргүүлнэ.

9 дүгээр зүйл.Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

9.1.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1.энэ хуулийн 14.4, 16.1-т заасныг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах;

9.1.2.карбон зах зээлийн бодлогыг тодорхойлох, холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

9.1.3.ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх, санхүүгийн хөшүүрэг, хэрэгсэл ашиглах санал боловсруулах, удирдах, үр ашигтай хуваарилах, зарцуулалтад хяналт тавих;

9.1.4.карбон кредитийн асуудлаарх хоёр болон олон талт гэрээ, хэлэлцээрийн төсөл боловсруулах, Засгийн газрыг төлөөлж, хэлцэлд оролцох;

9.1.5.Монгол Улсын олон улсын гэрээнд тусгагдсан хамтын шийдвэр гаргах хорооны бүрэлдэхүүнийг уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн томилох.

9.2.Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.2.1.уур амьсгалын өөрчлөлтийн суурь судалгааг хийх, өнөөгийн болон ирээдүйн хандлагыг үнэлэн тогтоох ажлыг зохион байгуулах;

9.2.2.уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эрсдэл, өртөх байдлын үнэлгээг салбараар болон бүс нутгаар хийх;

9.2.3.уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөлтэй тэмцэх зорилт, арга хэмжээг салбар, бүс нутаг бүрээр эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад талуудтай хамтран тодорхойлох;

9.2.4.улсын хэмжээнд эдийн засгийн салбараар хүлэмжийн хийн тооллого хийх;

9.2.5.уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг байдал болон эрсдэлийн үнэлгээ хийх журмыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах, хэрэгжилтийг хангах;

9.2.6.Үндэсний зорилтын хэрэгжилтийг тооцох, тайлагнах, баталгаажуулах журмыг эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах, хэрэгжилтийг хангах;

9.2.7.хүлэмжийн хийн тооллогыг өмчийн хэлбэр үл харгалзан хийх мэргэжлийн аргазүй, зөвлөмжөөр хангах;

9.2.8.уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой олон улсын гэрээгээр үүрэг хүлээсэн тайланг боловсруулах;

9.2.9.хуульд заасан бусад бүрэн эрх.

9.3.Бусад төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.3.1.энэ хуулийн 6.1.1-д заасан бодлогын баримт бичигтэй уялдуулан тухайн салбарын хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах;

9.3.2.хүлэмжийн хийн ялгарал, дасан зохицох суурь түвшин, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээхтэй холбоотой мэдээллийн нэгдсэн санг хөтлөх;

9.3.3.энэ хуулийн 9.3.2-д заасан өгөгдөл, мэдээллийг холбогдох журмын дагуу уур амьсгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

9.3.4.тухайн салбарын хүлэмжийн хийн ялгарлыг тооцох аргачлалыг уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;

9.3.5.тухайн салбарын уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг байдал болон эрсдэлийн үнэлгээг боловсруулж, хэрэгжүүлэх;

9.3.6.хуульд заасан бусад.

10 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын бүрэн эрх

10.1.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн аймаг, нийслэлийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг баталж, гүйцэтгэлд хяналт тавина.

11 дүгээр зүйл.Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

11.1.Энэ хуулийн 6.1.1-д заасан хөтөлбөр, Үндэсний зорилттой уялдуулан тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.

11.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд шинжлэх ухааны байгууллагаар хийлгэсэн уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл болон эмзэг байдлын үнэлгээний үр дүнг үндэслэн хариу арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

12 дугаар зүйл.Хүлэмжийн хийн бүртгэл хариуцсан байгууллага

12.1.Хүлэмжийн хийн бүртгэл хариуцсан байгууллага нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

12.1.1.Үндэсний зорилтын биелэлтийг хянахад шаардлагатай өгөгдөл, мэдээг цуглуулж бүртгэлжүүлэх;

12.1.2.хүлэмжийн хийн үндэсний тооллогын өгөгдөл, мэдээллийг хадгалах, тогтмол шинэчлэх;

12.1.3.хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээх төсөл, хөтөлбөр, карбон кредитийн бүртгэлийн системийг холбогдох журмын дагуу удирдаж, нээлттэй мэдээлэх;

12.1.4.хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээх төсөл, хөтөлбөр, карбон кредит бүртгэхэд шаардагдах мэдээлэл, баримт бичгийг төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч талаас гаргуулах;

12.1.5.улс хооронд шилжүүлж, арилжаалагдсан баримт бичгийг үндэслэн хүлэмжийн хийн тооллогод харгалзах тохиргоо, өөрчлөлтийг хийн үндэсний болон олон улсын түвшинд ил тод тайлагнаж давхар тоололтоос сэргийлэх;

12.1.6.Үндэсний зорилтын гүйцэтгэл, хүлэмжийн хийн үндэсний тайланг тогтсон хугацаанд, олон улсын арга зүй, холбогдох журмын дагуу боловсруулж, тайлагнах.

12.2.Хүлэмжийн хийн бүртгэл хариуцсан байгууллагын ажиллах журмыг эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨЛЛИЙГ ДАВАН ТУУЛАХ, ДАСАН ЗОХИЦОХ

13 дугаар зүйл.Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ

13.1.Уур амьсгалын өнгөрсөн хугацааны болон ирээдүйн чиг хандлагад үндэслэн нийгэм, эдийн засгийн салбар, бүс нутаг бүрээр ус цаг уур, орчны хяналт шинжилгээний төрийн захиргааны байгууллага нь холбогдох төрийн захиргааны болон эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран уур амьсгалын өөрчлөлтийн бодит болон болзошгүй сөрөг нөлөөлөл, түүний үр дагаварт өртөх эмзэг байдал, эрсдэлийг батлагдсан аргачлалын дагуу тодорхойлсон уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээг хийнэ.

13.2.Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээг үндэсний онцлогийг харгалзан, олон улсын шалгуур үзүүлэлт, аргазүйтэй нийцүүлэн 4 жил тутам хийнэ.

13.3.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, хөрөнгийн бирж дээр хувьцаа нь нээлттэй арилжаалагддаг хувьцаат компани хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулахад уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийж, нийтэд ил тод мэдээлнэ.

13.4.Дасан зохицлын тэргүүлэх салбарт уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх нөлөөллийг харгалзан дасан зохицох арга хэмжээг төлөвлөж, шаардлагатай санхүүжилтийг уур амьсгалын эрсдэлийн үнэлгээг үндэслэн тооцож, сум, орон нутгийн хөгжлийн санд хуваарилна.

14 дүгээр зүйл.Уур амьсгалын өөрчлөлт, нөлөөллийг даван туулах, дасан зохицох

14.1.Байгаль орчны цогц байдлыг хангаж, уур амьсгалын өөрчлөлт, нөлөөллийг даван туулах, дасан зохицох нь дараах харилцан уялдаа холбоотой үйл ажиллагаанаас бүрдэнэ:

14.1.1.уур амьсгалын өөрчлөлтөд нийцсэн хөгжлийн загварыг бий болгох, эдийн засгийг төрөлжүүлэх;

14.1.2.уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, эрт сэрэмжлүүлэх, зарлан мэдээлэх, хариу арга хэмжээ авах тогтолцоог бэхжүүлэх;

14.1.3.уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй усны хомсдолыг бууруулах, түүний хангамж, аюулгүй байдлыг хангах, үер, усны аюулт үзэгдэлд тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх;

14.1.4.уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, дасан зохицох чадвартай, тогтвортой хөдөө аж ахуйг дэмжих, хүнсний аюулгүй байдлыг хангах;

14.1.5.уур амьсгалын өөрчлөлтийн нийтийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тэсвэрлэх чадавхыг бий болгох, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс үүдэлтэй өвчлөл, эндэлтийг бууруулах;

14.1.6.байгальд суурилсан дасан зохицох арга хэмжээг өргөжүүлж, байгалийн нөөцийн тогтвортой менежмент, экосистемийн тэнцвэрт байдлыг хангах;

14.1.7.уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, дасан зохицох чадвартай, тогтвортой дэд бүтцийг хөгжүүлэх, суурь үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах;

14.1.8.уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий бүлгийн чадавхыг бэхжүүлэх;

14.1.9.уур амьсгалын өөрчлөлтийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, бэлэн байдлыг хангах чадавхыг бүрдүүлж, олон талын оролцоог нэмэгдүүлэх;

14.1.10.уламжлалт мэдлэг, орон нутгийн онцлогт нийцсэн арга хэмжээг хэрэгжүүлж, соёлын өв, дурсгалыг хамгаалах;

14.1.11.уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, тогтвортой амьдрах, ажиллах орчныг бүрдүүлэх, түүнд чиглэсэн ногоон, эрчим хүчний хэмнэлттэй барилгын салбарын холбогдох стандарт нормыг сайжруулах;

14.1.12.ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах ажлын хүчин чадал, чадавх, үр нөлөөг нэмэгдүүлэх;

14.1.13.уур амьсгалын Үндэсний хорооноос тогтоосон бусад арга хэмжээ.

14.2.Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа хүн, хуулийн этгээд өмчийн хэлбэрээс үл харгалзан өөрийн үйл ажиллагаа явуулж буй салбарт энэ зүйлийн 14.1-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зарчим баримтална.

14.3.Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах, дасан зохицох зорилт, арга хэмжээг энэ хуулийн 8.1.2.6-д заасан салбар, бүс нутаг бүрээр уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тодорхойлж, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох байгууллагууд бодлого, хөтөлбөр, төлөвлөлтийн баримт бичигт тусган хэрэгжүүлнэ.

14.4.Дасан зохицох зорилт, арга хэмжээ нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээнд үндэслэгдэх ба Үндэсний зорилт, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох Үндэсний төлөвлөгөөтэй уялдсан байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХҮЛЭМЖИЙН ХИЙН ТЭНЦВЭРИЙГ ХАНГАХ

15 дугаар зүйл.Хүлэмжийн хийн тооллого, баталгаажуулалт, тайлагнал

15.1.Хүлэмжийн хийн тэнцвэрийг хангах зорилтыг нийгэм, эдийн засгийн дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого, стратегид тусган хэрэгжүүлнэ.

15.2.Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хугацаанд энэ хуулийн 15.8-д заасан журмын дагуу хүлэмжийн хийн тооллогыг зохион байгуулна.

15.3.Хүлэмжийн хийн тооллогыг аймаг, хот, улсын хэмжээнд болон эдийн засгийн салбар бүрээр олон улсын аргачлал, үндэсний онцлогийг харгалзсан арга зүйгээр Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын томилсон этгээд хийж, энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасан мэдээллийн санд байршуулж нийтэд мэдээлнэ.

15.4.Холбогдох төрийн болон нутгийн захиргааны байгууллага, бусад байгууллага нь энэ хуулийн 15.3-т заасан тооллого хийхэд шаардлагатай өгөгдөл мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

15.5.Хүлэмжийн хийн тооллогын тайлан дүнг уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилсон хөндлөнгийн мэргэжлийн баг, шинжээч баталгаажуулна.

15.6.Энэ зүйлийн 15.5-д заасан тайланг олон талын оролцоотой баталгаажуулах хэлэлцүүлэг зохион байгуулсан байвал зохино.

15.7.Хүлэмжийн хийн тооллогын тайланг олон улсын жишигт нийцсэн загварт нийцүүлэн боловсруулж, холбогдох талуудад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

15.8.Хүлэмжийн хийн тооллого зохион байгуулах журмыг уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.

16 дугаар зүйл.Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, зайлуулах, шингээлтийг нэмэгдүүлэх

16.1.Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, зайлуулах, шингээлтийг нэмэгдүүлэх, дүйцүүлэх зорилтыг уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тодорхойлж, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох байгууллагууд бодлого, хөтөлбөр, төлөвлөлтийн баримт бичигт тусган хэрэгжүүлнэ.

16.2.Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн Үндэсний зорилтыг 5 жил тутамд шинэчлэн тодорхойлж, холбогдох газарт хүргүүлнэ.

16.3.Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа хүн, хуулийн этгээд өмчийн хэлбэрээс үл харгалзан өөрийн үйл ажиллагаандаа хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, зайлуулах, шингээлтийг нэмэгдүүлэх зарчмыг баримтална.

16.4.Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, зайлуулах, шингээлтийг нэмэгдүүлэх, дүйцүүлэх төсөл, хөтөлбөр нь сайн дурын, хоёр талт болон олон талт хэлбэртэй байж болно.

16.5.Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагаа нь дараах хэлбэртэй байна:

16.5.1.орчны бохирдлыг бууруулж, даван туулах чадвартай цэвэр эрчим хүч үйлдвэрлэл, түгээлт, үр ашигтай хэрэглээг дэмжих;

16.5.2.байгаль орчинд ээлтэй тээврийн тогтолцоог бүрдүүлэх;

16.5.3.байгалийн нөөцийг хэмнэх, орцыг багасгах техник технологийг нэвтрүүлж, нутагшуулах;

16.5.4.малтмал түлшний хэрэглээг бууруулах, орлуулах;

16.5.5.хүлэмжийн хийн ялгарал багатай үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээг төлөвшүүлэх;

16.5.6.хог хаягдлын менежментийн тогтолцоог сайжруулах, орчны бохирдлыг бууруулах;

16.5.7.эдийн засгийн салбарын ангилал бүрээр хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагааны хүний нөөц, санхүү болон техник технологийн чадавхыг сайжруулах;

16.5.8.уур амьсгалын Үндэсний хорооноос тогтоосон бусад арга хэмжээ.

16.6.Хүлэмжийн хийг зайлуулах үйл ажиллагаа нь дараах хэлбэртэй байна:

16.6.1.байгалийн зүй тогтолд нийцсэн шийдлийг дэмжих;

16.6.2.бэлчээрийн даацад нийцсэн мал аж ахуйг хөгжүүлж, хөрс, ургамлын бүрхэвчийг сэргээх, бэлчээрийг хамгаалах;

16.6.3.ойн хомсдол, доройтлыг бууруулж, нөхөн сэргээх;

16.6.4.хүлэрт намаг, ус намгархаг газар, цэвдэгт хөрсийг хадгалан хамгаалах;

16.6.5.эвдэрч доройтсон хөрс, газрыг нөхөн сэргээх;

16.6.6.хот, суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх;

16.6.7.хурааж агуулах буюу агаар мандалд байгаа, эсхүл үйлдвэрлэл, хэрэглээний эх үүсвэрээс ялгарч буй нүүрстөрөгчийн давхар ислийг ялган авч геологийн болон бусад бүтцэд хадгалах технологийг хөгжүүлэх;

16.6.8.уур амьсгалын Үндэсний хорооноос тогтоосон бусад арга хэмжээ.

16.7.Хүлэмжийн хийн ялгарал бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ зах зээлийн зарчимд суурилсан олон талын оролцоог хангасан урамшуулал, дэмжлэгийн хөшүүргийг нэвтрүүлнэ.

16.8.Хүлэмжийн хийн ялгарал бууруулахад чиглэсэн арга хэмжээ нь хүний эрүүл мэнд, байгаль орчин, эдийн засаг, хувийн хэвшилд ээлтэй, уур амьсгалд сөрөг нөлөөгүй, цэвэр технологийг дэмжсэн байвал зохино.

ТАВДУГААР БҮЛЭГ КАРБОН КРЕДИТ ҮҮСГЭХ, БАТАЛГААЖУУЛАХ, АРИЛЖААЛАХ

17 дугаар зүйл.Карбоны зах зээлийн хэлбэр

17.1.Карбон зах зээл нь олон улсын болон үндэсний түвшинд сайн дурын хэлбэрээр хэрэгжинэ.

17.2.Сайн дурын зах зээлийн карбон кредит нь эрх бүхий төрийн байгууллагын зөвшөөрөлгүй байна.

17.3.Карбоны зах зээл олон нийтэд нээлттэй, ил тод байх нөхцөлийг хангана.

18 дугаар зүйл.Карбон кредитийг баталгаажуулах, бүртгэх

18.1.Үндэсний түвшинд зохицуулах Засгийн газраас тогтоосон эрх бүхий этгээд эсхүл эрх шилжүүлсэн тохиолдолд энэ хуулийн 9.1-д заасан байгууллага карбон кредитийг олгоно.

18.2.Карбон кредитийг төсөл, хөтөлбөрийн үр дүнд үүсгэх бөгөөд дараах шалгуурыг хангасан байна:

- 18.2.1.үр ашигтай байх;
- 18.2.2.тогтвортой байх;
- 18.3.3.найдвартай байх;
- 18.2.4.чанарын баталгаатай байх;

18.3.Энэ хуулийн 18.2-т заасан шалгуур нь дараах нөхцөлийг хангасан байна:

18.3.1.энэ хуулийн 18.2.1-д заасан үр ашигтай байх шалгуур нь дараах нөхцөлийг хангасан байна:

18.3.1.1.карбоны төсөл, хөтөлбөр нь санхүүгийн үр ашиггүй, карбоны санхүүжилт авахгүйгээр, карбон кредитийг арилжаалахад олох орлогоос өөр эх үүсвэрээр хэрэгжих боломжгүй буюу нэмэлтээр үүсгэсэн байх;

18.3.1.2.уур амьсгалын үйл ажиллагаанд бодитой хувь нэмэр оруулах, хүлэмжийн хийн ялгарлын бодитой баталгаажуулж болохуйц бууруулалт, шингээлтийг илэрхийлэх, өндөр итгэл үнэмшилтэй байх;

18.3.2.энэ хуулийн 18.2.2-д заасан тогтвортой байх шалгуур нь дараах нөхцөлийг хангасан байна:

18.3.2.1.хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахаас гадна экосистем, нийгэм, эдийн засагт нэмэлт эерэг нөлөө үзүүлэх, харилцан ашиг тустай байх;

18.3.2.2. цэвэр хохирлоос сэргийлэх буюу карбоны дүйцүүллийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үр дүнгээс гадна үүсдэг нийгэм, эдийн засаг, байгаль орчны эерэг, сөрөг нөлөөллийн харьцаанд сөрөг нөлөөлөл нь давамгайл бус байх бусад нийт цэвэр хохирлыг багасгах, түүнээс сэргийлэхийг;

18.3.2.3.алдагдлаас сэргийлэх буюу нэг бүс нутагт хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, дүйцүүлэх үйл ажиллагаа нь өөр газар, эсхүл өөр хэлбэрээр ялгаралтыг нэмэгдүүлэхгүй, нийтдээ үр дүнтэй байх;

18.3.3.энэ хуулийн 18.2.3-д заасан найдвартай байх шалгуур нь дараах нөхцөлийг хангасан байна:

18.3.3.1.хүлэмжийн хийн ялгарлын бууруулалт, дүйцүүлэлтийг тусгайлсан гэрээгээр эзэмшигчийн баталгаажуулж эзэнтэй болгож давхардуулан тооцоолох болон тооцогдохоос сэргийлэх олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүндтэй стандарт, аргачлалын ил тод, найдвартай бүртгэл, хяналт, зөвшөөрлийн системийг ашиглах, тухайн карбон кредитийг гүйлгээнээс гаргах замаар давхар тооцогдохоос зайлсхийх буюу давхардуулан тооцогдохгүй байх;

18.3.3.2.хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээх үйл ажиллагаа дууссанаас хойш үр дүн нь хадгалагдаж үлдэх;

18.3.4.энэ хуулийн 18.2.4-д заасан чанарын баталгаатай байх шалгуур нь дараах нөхцөлийг хангасан байна:

18.3.4.1.хүлэмжийн хийн ялгарлын бууруулалт, шингээлт болон дүйцүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүн бодитой, хэмжигдэхүйц, нэмэлтээр үүсгэгдсэнийг хөндлөнгийн, бие даасан баталгаажуулах боломж нөхцөлийг бүрдүүлсэн буюу баталгаажих боломжтой байх;

18.3.4.2. карбон кредит бүр түүнийг үүсгэж буй хүлэмжийн хийн ялгарлын бууралт, шингээлт болон дүйцүүлэлтийн төсөл хөтөлбөртэй холбож төлөвлөхөөс нь эхэлж эргэлтээс гаргах хүртэлх бүх үе шатанд нь бүртгэлтэй хянах боломжтой байх буюу мөшгөх боломжтой байх;

18.4.Карбон кредит үүсгэх төсөл, хөтөлбөр нь холбогдох үндэсний болон олон улсын байгууллагын баталсан удирдамж, аргачлал, стандарттай нийцсэн байна.

18.5.Карбон кредит нь олон улс болон үндэсний түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хангасныг эрх бүхий этгээдээр баталгаажуулна.

18.6.Үндэсний түвшинд хөндлөнгийн баталгаа, нотолгоо гаргах эрх бүхий этгээдэд уур амьсгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шалгуур дээр үндэслэн Үндэсний хороо эрх олгоно.

18.7.Карбоны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч нь байнгын хяналтын төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийн тайланг уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тодорхойлсон бүртгэл, ил тод тайлагналын асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ.

18.8.Хоёр талт болон олон талт хамтын ажиллагааны хүрээнд бүртгүүлж, зөвшөөрөл авсан төсөл хөтөлбөрүүдээс үүссэн карбон кредитийг олон улсын гэрээнд заасан нөхцөлийн дагуу эрх авсан байгууллага нь тогтсон журмаар олгоно.

18.9.Карбон кредит нь худалдаалах, арилжаалах, шилжүүлэх эрх бүхий төрийн байгууллагын зөвшөөрөлтэй байх ба хүлэмжийн хийн тооллого, бүртгэлд тусгаж давхардуулан тооцоологдохоос зайлсхийнэ.

19 дүгээр зүйл.Карбон кредитийн бүртгэл, худалдаа, арилжаа, шилжүүлэг

19.1.Карбоны зах зээлийн арилжаанд шаардлага хангасан, сонирхсон этгээд оролцож болно.

19.2.Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх зорилгод нийцүүлэн карбоны зах зээлийг дэмжих бодлогыг эрх бүхий этгээд тодорхойлно.

19.3.Карбон кредитийг худалдах, арилжих, шилжүүлэх зөвшөөрлийг Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

19.4.Энэ хуульд заасны дагуу баталгаажиж, бүртгэгдсэн карбон кредит нь төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчийн өмч байна.

19.5.Карбон зах зээлийн хүрээнд бий болсон хүлэмжийн хийн ялгарлын бууралт, шингээлтийг олон улсад худалдах, арилжаалах зөвшөөрөл олгох, бүртгэх, хянах журмыг уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.

19.6.Үндэсний карбон кредитийн бүртгэл хариуцан, хүлэмжийн хийн тооллогод тохируулга хийж ил тод тайлагнах үүрэг бүхий этгээдийг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу батална.

19.7.Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагаанаас үүссэн карбон кредитийг хоёр талын болон олон талын арилжаанд оролцогч талууд баталгаажуулснаар шилжих боломжтой болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭ

20 дугаар зүйл.Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, үнэлгээ

20.1.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага уур амьсгалын өөрчлөлтийг хянаж, үнэлж, ирээдүйн төлөв байдал, чиг хандлагыг тодорхойлно.

20.2.Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, үнэлгээг шинжлэх ухааны академи, их сургуулиудын дэргэдэх эрдэм шинжилгээний бусад байгууллагатай хамтран хийнэ.

21 дүгээр зүйл.Уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллийн нэгдсэн сан

21.1.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь уур амьсгалын өөрчлөлтийн мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд ашиглах нэгдсэн сан бүрдүүлнэ.

21.2.Уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллийн нэгдсэн сан дараах мэдээллээс бүрдэнэ:

21.2.1.уур амьсгалын үндсэн мэдээлэл;

21.2.2.холбогдох байгууллагын бүртгэл, мэдээлэл;

21.2.3.хүлэмжийн хийн тооллогын өгөгдөл, мэдээлэл;

21.2.4.уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий болон нэн өртөмтгий байгалийн нөөц, байгалийн тогтолцоо, бүрэлдэхүүн хэсгийн ангиллын өгөгдөл, мэдээлэл;

21.2.5.уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг байдал болон эрсдэлийн үнэлгээний мэдээ, тайлан;

21.2.6.хүлэмжийн хийн ялгарлын бууралт, шингээлтийн өгөгдөл, мэдээлэл;

21.2.7.энэ хуульд заасан карбон зах зээлийн бүртгэлтэй холбоотой мэдээлэл;

21.2.8. уур амьсгалын өөрчлөлтөд дүн шинжилгээ хийхэд шаардагдах бусад мэдээлэл.

21.3.Уур амьсгалын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх харилцааг энэ хууль болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна.

21.4.Энэ хуулийн 21.1-д заасан мэдээллийн нэгдсэн сан дараах ангилалтай байна:

- 21.4.1.улсын;
- 21.4.1.аймаг, нийслэлийн.
- 21.4.1.салбарын
- 21.4.1.бусад

21.5.Монгол Улсын газар нутаг дээр хийгдсэн уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, тайлан, мэдээллийг эзэмшигч энэ хуулийн 21.2-т заасан мэдээллийн нэгдсэн санд хүргүүлэх үүрэгтэй.

21.6. Энэ хуулийн 21.2-т заасан мэдээллийг эзэмшиж байгаа холбогдох байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд мэдээллийн нэгдсэн санд хүргүүлэх үүрэгтэй.

ДОЛДУГААР БҮЛЭГ НОГООН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО

22 дугаар зүйл.Ногоон санхүүжилтийн эх үүсвэр

22.1.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, урьдчилан сэргийлэх, даван туулах, хор хохирлыг арилгах, хүлэмжийн хийн ялгарлыг багасгах, бууруулах, ялгах, шингээх, хадгалах болон карбоны зах зээлийг хөгжүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлсэн ногоон санхүүжилтээр дэмжинэ.

22.2.Энэ хуулийн 22.1-д заасан зорилгод нийцүүлж дараах төрлийн санхүүжилтийн хөшүүргийг үзүүлж болно:

22.2.1.төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
22.2.2.хөрөнгө оруулалт, санхүүжилт, зээл олгох, зээлийн батлан даалт гаргах;

- 22.2.3.татварын дэмжлэг үзүүлэх;
- 22.2.4.Засгийн газрын баталгаа гаргах;
- 22.2.5.Засгийн газрын тусгай сангаар дамжуулан санхүүжилт олгох;
- 22.2.6.төсөл, хөтөлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлэх.

22.3.Ногоон санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

- 22.3.1.улсын болон орон нутгийн төсөв;
- 22.3.2.гадаадын зээл, тусламж;
- 22.3.3.гадаад, дотоодын хуулийн этгээд, хувь хүний хөрөнгө оруулалт;
- 22.3.4.төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн санхүүжилт;
- 22.3.5.байгаль орчин, уур амьсгалын сан;
- 22.3.6.хууль тогтоомжид нийцсэн бусад.

22.4.Ногоон санхүүжилт, хөрөнгө оруулалтын үндэсний стратегийг уур амьсгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

22.5.Ногоон санхүүжилтийг дэмжих хөшүүрэг, эх үүсвэрийг Монгол Улсын нэгдсэн төсөв ба мөнгөний бодлого, санхүүгийн салбарын зохицуулалтад тусгана.

23 дугаар зүйл.Ногоон санхүүжилтийн хэрэгсэл

23.1.Ногоон санхүүжилтэд дараах хэрэгслийг ашиглах:

- 23.1.1.ногоон бонд;
- 23.1.2.ногоон зээл;
- 23.1.3.зорилтот бонд болон зээл;
- 23.1.4.карбон зах зээл, карбон кредит болон дүйцүүлсэн нэгжийн арилжаа;
- 23.1.5.ногоон хөрөнгө оруулалт;
- 23.1.6.төр, хувийн хэвшлийн холимог санхүүжилт;
- 23.1.7.ногоон даатгал;
- 23.1.8.хууль тогтоомжид нийцсэн бусад.

23.2.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улс орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, банк санхүүгийн салбарын зээл, даатгалын үйлчилгээнд энэ хуулийг мөрдөх, хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн төрөл бүрийн хөшүүргийг нэвтрүүлнэ.

23.3.Ногоон санхүүжилтэд хамрагдах төсөл, хөтөлбөр нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

- 23.3.1.байгаль орчинд ээлтэй, уур амьсгалд сөрөг нөлөөгүй байх;
- 23.3.2.үндэсний болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тогтолцоо, зарчим, батлагдсан стандарт, зохицуулалтын удирдамж, арга зүй, шаардлагад нийцсэн байх;
- 23.3.3.Үндэсний зорилтын хэрэгжилтэд хувь нэмэр оруулахаар байх.

23.4.Засгийн газар ногоон санхүүжилтийн хэрэгслийг ашиглан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх үйл ажиллагааг зохицуулах зорилгоор тусгайлсан журам баталж болно.

23.5.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Ногоон таксономыг боловсруулж, Засгийн газар батална.

24 дүгээр зүйл.Ногоон санхүүжилтийн хяналт

24.1.Ногоон санхүүжилтийн үр дүнг хэмжиж, хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар баталгаажуулна.

24.2.Ногоон санхүүжилтийн үр дүнг баталгаажуулах мэргэжлийн байгууллагыг стандартын дагуу магадлан итгэмжилнэ.

24.3.Ногоон санхүүжилтийн хөрөнгийн удирдлагын тайланг жил бүр гаргаж, олон нийтэд мэдээлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД

25 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

25.1.Энэ хуулийг зөрчсөн төрийн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

25.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

25.3.Энэ хуулийг зөрчсөн этгээдэд торгууль ногдуулсан нь зөрчлийн хариуцлагаас чөлөөлөгдөх эсвэл зөрчлийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

26 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

26.1.Энэ хууль нь 20... оны ... сарын ... -ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.